



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 11 (148)

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг:*

- Ажилд томилон ажиллуулах тухай

*Монгол Улсын Засгийн газрын тогтоол:*

- Банкны хувьчлалын хөтөлбөр батлах тухай
- Цагдаагийн академи байгуулах тухай
- Тусгай татвар ногдуулах тухай
- Цаг агаарын мэдээ дамжуулалтыг тогтмолжуулах тухай

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот  
2000 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны гуравдугаар сарын 30

№11 (148)

## Гарчиг

### Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг

142. Ажилд томилон ажиллуулах тухай Дугаар 27 229

### Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

143. Банкны хувьчлалын хөтөлбөр батлах тухай Дугаар 15 230

144. Цагдаагийн академи байгуулах тухай Дугаар 17 232

145. Тусгай татвар ногдуулах тухай Дугаар 18 232

146. Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 19 232

147. "Боловсролын салбарыг 2000-2005 онд хөгжүүлэх стратеги" баримт бичгийг зөвшөөрөх тухай Дугаар 20 233

148. Хууль зүйн яамны зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай Дугаар 21 233

149. Цаг агаарын мэдээ дамжуулалтыг тогтмолжуулах тухай Дугаар 26 234

150. Журам батлах тухай Дугаар 28 234

151. Химийн бодисын аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 29 236

152. Орон нутгийн мэргэжлийн хяналтын албадын талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 31 238

153. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай Дугаар 34 242

### Гурав. Яам, агентлагийн акт

154. Журам батлах тухай /Гэгээрлийн сайдын 1999-12-31-ний тушаал/ Дугаар 286 250

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 3 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

### Ажилд томилон ажиллуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

1. Үндэсний аюулгүй байдлын гадаад бодлогын уялдаа зохицуулалтын асуудал хариуцсан референтийг Гадаад харилцааны яамнаас, төрийн нууц, тагнуулын бодлогын асуудал хариуцсан референтийг Тагнуулын ерөнхий газраас, хуулийн асуудал эрхэлсэн референтийг Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газраас, Зөвлөлийн бичиг хэрэг, нууц хариуцсан ажилтныг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний ерөнхий штабаас УАБЗ-ийн Ажлын албанд томилон ажиллуулж байхыг Зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

2. Нэр заасан албан тушаалтан нарыг төрийн албаны тухай хуулинд төрийн захиргааны албан хаагчдыг сэлгэн ажиллуулахаар заасан хугацаа дуусмагц хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь заалтын дагуу урьд эрхэлж байсан ажил, ал-

бан тушаалыг нь бууруулахгүйгээр эргүүлэн томилж байхыг Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга, Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга, Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга, Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга, Тагнуулын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны төрийн тусгай албан тушаалд томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг тухайн байгууллагад ажилласнаар нь үргэлжлүүлэн тооцож, цэргийн болон цагдаагийн цолыг хэвээр эдлүүлж байхыг Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга, Зэвсэгт хүчний ерөнхий штаб, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

### Банкны хувьчлалын хөтөлбөр батлах тухай

Улсын Их Хурлын 1999 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Банкны хувьчлалын талаар баримтлах үндсэн чиглэл"-ийн 15-д заасны дагуу Монгол банкттай зөвшилцөн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Банкны хувьчлалын хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Банкны хувьчлалыг дээрх хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэхийг Сангийн сайд

Я.Очирсүх, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт даалгасугай.

Монгол Улсын

Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Сангийн сайд

Я.ОЧИРСҮХ

Засгийн газрын 2000 оны 15 дугаар тогтоолын хавсралт

### БАНКНЫ ХУВЬЧЛАЛЫН ХӨТӨЛБӨР

#### Нэг.Хөтөлбөрийн зорилт

болох богино хугацаанд, нээлттэй, ил тод /телевиз, радио болон мэдээллийн бусад хэрэгслээр гадаад, дотоодод сурталчлах/, шударга, өрсөлдөөнтэй байдлаар хэрэгжүүлнэ.

4. Банкны хувьчлал, бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхдээ хадгаламж эзэмшигч, харилцагчид болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироохгүй байх зарчмыг баримтална.

5. "Банкны хувьчлалын талаар баримтлах үндсэн чиглэл"-ийн 2.9-т заасны дагуу банкний стратегийн хөрөнгө оруулагчдад хувьчлах зарчмыг тэргүүн зэрэгт тавина /стратегийн хөрөнгө оруулагч гэдэгт өөрийн орны болон олон улсын банк, санхүү-гийн салбарт олон жил нэр хүндтэй ажилласан, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц зэрэглэл бүхий, манай улсын банкны салбарт урт хугацааны хөрөнгө оруулалт хийж, түүнийхээ үр шимийг үзэх зорилго бүхий банк, санхүүгийн байгууллагыг ойлгоно/.

6. Банкны хувьчлалын арга хэлбэр болон аргачлал нь тухайн банкны төрийн мэдлийн хувьцааг худалдсанаас орох орлогыг нэмэгдүүлсэн байх ёстой. Гэвч хамгийн өндөр үнэ нь саналыг шалгаруулах болон худалдан авагчийг сонгох цорын ганц үзүүлэлт болохгүй.

7. Банкны хувьчлалыг хэрэгжүүлэхдээ хувьчлалд оролцож буй этгээдүүд (цаашид оролцогч гэх)-ийн дундаас мэргэжлийн өндөр ур чадвар, үйл ажиллагааны

1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь банкны салбар дахь төрийн өмчийн давамгайлах оролцоог бууруулан хувьчлах, бүтцийн өөрчлөлт хийх, мөн зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах банк, санхүүгийн системд чухал шаардлагатай эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх үндсэн дээр гадаад, дотоодын санхүүгийн чөлөөт эх үүсвэрийг монголд татаж, үр ашигтай хуваарилан эдийн засгийн бодит секторын хөгжлийг дэмжин тэтгэх болон өсөлтийг хангах чадвартай, тогтвортой, найдвартай, өрсөлдөх чадвартай банкны шинэ тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкуудыг хувьчлах буюу холбогдох бүтцийн өөрчлөлт хийхэд Монгол Улсын Банкны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон УИХ-ын 1999 оны 54 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдан гарсан "Банкны хувьчлалын талаар баримтлах үндсэн чиглэл" (цаашид "Банкны хувьчлалын талаар баримтлах үндсэн чиглэл" гэх)-д үндэслэн боловсруулсан энэхүү хөтөлбөрийг баримтална.

#### Хоёр.Банкийг хувьчлах зарчим

3. Монголын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шаардлагад нийцсэн банкны үр ашигтай тогтолцоог бий болгох зорилгоор банкны хувьчлалыг аль

туршлагыг үндэслэн олон улсад нэр хүнд бүхий банкныг сонгон шалгаруулах, хувьчлалд хамрагдаж буй банкны цаашдын бизнес төлөвлөгөө, стратеги, санхүүгийн чадвар, банкнд оруулах нэмэлт хөрөнгө зэрэг шалгуурыг тэргүүн ээлжинд үндэслэл болгоно.

8.Хувьчлалд хамрагдаж буй банкны үйл ажиллагааг хувьчлалын дараагаар олон улсын стандартад нийцүүлсэн байхыг шаардана.

## Гурав.Хувьчлах арга

9.Банкны төрийн мэдлийн хувьцааг хувьчлахдаа дараахь аргыг дангаар буюу хослуулан хэрэглэнэ:

а/үрэлдаант шалгаруулалт;  
б/төрийн өмчийн хувьцаа, хувь хөрөнгийг худалдах;

в/төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкуудыг хамтарсан хэлбэрээр өөрчлөн байгуулах зэрэг.

10.Тухайн банкны эдийн засаг болон санхүүгийн байдлаас шалт-гаалан хувьчлах буюу бүтцийн өөрчлөлт хийх арга хэлбэр нь банк тус бүр дээр өөр байж болно.

11.Хувьчлах арга хэлбэрийг сонгон авсан талаар нарийвчилсан тайлбар болон үндэслэлийн хамт хувьчлалын саналд тусгасан байна.

## Дөрөв.Банкны хувьчлалыг хэрэгжүүлэх аргачлал

12.Төрийн шууд эзэмшлийн хувь-цааг хувьчлах болон бүтцийн өөрчлөлт хийх саналыг банк бүрээр Төрийн өмчийн хороо Сангийн яамтай зөвшилцөн боловсруулж Засгийн газарт оруулж батлуулна.

13.Төрийн шууд бус эзэмшлийн хувьцаа /төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газруудаас оруулсан хувь хөрөнгө/-г худалдсанаас орох орлогоос нэрлэсэн үнэтэй тэнцүү хэмжээгээр тухайн хувьцааг эзэмшигч үйлдвэрийн газарт, түүнээс давсан хэсгийг хувьчлалын орлогод тооцож улсын төсвийн дансанд төвлөрүүлнэ.

14.Банк тус бүрийг хувьчлах болон бүтцийн өөрчлөлт хийх батлагдсан санал нь уг хөтөлбөрийн салшгүй нэг хэсэг болох бөгөөд банкны хувьчлал хэрэгжих хэмжээгээр энэхүү санал нь уг хөтөлбөрийн нэгэн адил хуулийн хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болно.

15.Банк хувьчлах саналын төсөл болон хөрөнгө оруулагчдын зүгээс хүлээн авч болохуйц худалдах аргачлал боловсруулахад зөвлөх, хөрөнгө оруулагчдын зуучлагчийг авч ажиллуулж болно.

16.Хувьчлалд хамрагдаж байгаа банк нь Улсын Их Хурлаас баталсан үл хувьчлах хөрөнгийн жагсаалтад багтсан тохиолдолд тухайн банкныг хувьчлах саналыг Засгийн газарт танилцуулж Улсын Их Хурлаас холбогдох шийдвэр гарсны үндсэн дээр хувьчилна.

## Тав.Хувьчлах санал

17.Хувьчлах саналд дараахь зүйлийг тусгасан байна:

а/хувьчлах страте.и. арга хэлбэр, нөхцөлүүд, шаардлагатай тохиолдолд банк тус бүрээр нарийвчилсан тайлбар болон үндэслэл;

б/хувьчлах хөрөнгө /төрийн мэдлийн хувьцаа/-ийн хэмжээ, үнэлгээний тайлан болон доод үнэ;

в/хувьчлал /тендер/-ыг зохион байгуулах журам болон хугацаа;

г/сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан тэнцэл, дүн шинжилгээ;

д/аудитын тайлан;

е/эрх зүйн дүн шинжилгээ;

ж/хувьцаа худалдах, худалдан авах гэрээ;

з/бусад дэлгэрэнгүй мэдээлэл.

## Зургаа.Хувьчлалд хамрагдах төрийн өмч

18.Төрийн өмчийн оролцоотой банкууд:

№	Банкны нэр	Төрийн өмчийн эзлэх хувь
1	Худалдаа хөгжлийн банк	70
2	Шинэчлэл /үйлдвэрийн хувь нийлүүлсэн/ банк	46
3	Монгол шуудан банк	4,7
4	Хөдөө аж ахуйн банк	дахин тодотгож хувьчлах

## Долоо.Хэрэгжих хугацаа

19.Улсын Их Хурлаас батлагдсан үл хувьчлагдах эд хөрөнгийн жагсаалтад ороогүй банкны төрийн мэдлийн хувьцааг 2000 оны эхний хагас жилд багтаан хувьчилна.

20.Банкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд татан буугдсан болон төрийн эрх бүхий байгууллагын санаачилгаар цаашид төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банк шинээр байгуулаг-даагүй тохиолдолд тус хөтөлбөрийн хавсралтад буй банкуудыг хувьчилж дууссанаар хөтөлбөрийг хэрэгжиж дууссанд тооцно.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 2 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

### Цагдаагийн академи байгуулах тухай

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Цагдаагийн дээд сургуулийг цагдаагийн анхан шатны, үндсэн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, тэдгээрийг давтан сургах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чиг үүрэгтэй Цагдаагийн академи болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2.Цагдаагийн академийн бүтэц болон дүрмийг баталж мөрдүүлэхийг Хууль зүйн сайд Д.Ганболд, Гэгээрлийн сайд А.Баттөр нарт даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ**

**Хууль зүйн сайд Д.ГАНБОЛД**

**Гэгээрлийн сайд А.БАТТӨР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 2 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

### Тусгай татвар ногдуулах тухай

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны санал, Гаалийн тарифын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улсаас экспортод гаргах "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн 4103.10.00, 4301.00.12 кодоод хамрагдах ямаа, ишигний боловсруулаагүй арьсны ширхэг тутамд 1500 төгрөгийн тусгай татвар ногдуулсугай.

2.Энэ тогтоолыг 2000 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "Тусгай татвар ногдуулах тухай" Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 218 дугаар тогтоолыг 2000 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ**

**Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.СОДНОМЦЭРЭН**

**Сангийн сайд Я.ОЧИРСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 2 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

### Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Улсын Их Хурлын 1999 оны 71 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Журам батлах тухай" Засгийн газрын 1998 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2.Гадаад улсын шүүх, түүнийг орлосон байгууллагын шийдвэрээр улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн Монгол Улсын иргэнийг цагаатгуулах болон цагаатгагдсан хүмүүст тухайн улсын хууль тогтоомжийн дагуу олгогдох нөхөх олговрыг шилжүү-лэн авах асуудлаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Гадаад харилцааны сайд Н.Туяа, Сангийн сайд Я.Очирсүх нарт даалгасугай.



2.Мөн тогтоолоор баталсан "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн биелэлтийг зохион байгуулах журам"-д дор дурдсан өөрчлөлтүүд оруулсугай:

а/журмын 9 дэх заалтад "Засгийн газрын мэдээ" гэснийг "тус Комиссоос зохих журмын дагуу сонгон шалгаруулсан" гэж;

б/мөн журмын 11 дэх заалтад "Засгийн газрын мэдээ" гэснийг "энэ журмын 9-д заасан" гэж;

в/мөн журмын 4 дэх заалтын "а"-д "8.2" гэснийг "8.3", "б"-д "8.3" гэснийг "8.4" гэж тус тус өөрчлөх.

3.Журмын 6,7,8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4."Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль тогтоомжийн эмхтгэл"-ийг монгол, орос, англи хэл дээр хэвлэх зориулалтаар Засгийн газрын нөөц хөрөнгөөс 4,0 (дөрвөн) сая төгрөг гаргахыг Сангийн сайд Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

**Монгол Улсын  
Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ**

**Хууль зүйн сайд Д.ГАНБОЛД**

**Сангийн сайд Я.ОЧИРСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 2 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар  
хот

**"Боловсролын салбарыг 2000-2005  
онд хөгжүүлэх стратеги" баримт  
бичгийг зөвшөөрөх тухай**

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Боловсролын салбарыг 2000-2005 онд хөгжүүлэх стратегийг зөвшөөрсүгэй.

2.Энэхүү стратегид тусгагдсан төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Гэгээрлийн сайд А.Баттөр, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах.

хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Н.Туяа, Сангийн сайд Я.Очирсүх нарт даалгасугай.

**Монгол Улсын  
Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ**

**Гэгээрлийн сайд А.БАТТӨР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 2 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар  
хот

**Хууль зүйн яамны зохион байгуулалтын  
бүтцийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хууль зүйн яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

а/Төрийн захиргааны удирдлагын газар  
-захиргааны удирдлагын хэлтэс  
-гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс

б/Стратегийн бодлогын газар  
-төрийн байгууламжийн хууль тогтоомжийн шинэтгэлийн тасаг  
-иргэний хууль тогтоомжийн шинэтгэлийн тасаг

-эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлийн тасаг

в/Бодлого зохицуулалтын газар  
г/Мэдээлэл, мониторингийн газар  
-хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс  
-мэдээлэл сурталчилгааны тасаг  
2.Дээрх бүтцийн дагуу Хууль зүйн яамны ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн тогтоож мөрдүүлэхийг Хууль зүйн сайд Д.Ганболдод даалгасугай.

3.Яам болон Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агент-лагуудын улсын төвлөрсөн төсвийн төвлөрүүлэн захирагчаар Хууль зүйн сайд Д.Ганболдыг баталсугай.



4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 151 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл, мөн тогтоо-лоор баталсан хавсралтын 3.2, 3.3 дахь хэсэг, "Улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг ханган биелүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын

2-ны өдрийн 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын "7.Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар; 9.Цагдаагийн ерөнхий газар; 11.Шүүхийн ерөнхий зөвлөл" гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** Р.АМАРЖАРГАЛ  
**Хууль зүйн сайд** Д.ГАНБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 2 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

### Цаг агаарын мэдээ дамжуулалтыг тогтмолжуулах тухай

Ус,цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Ус, цаг уур, байгаль орчны шуурхай болон урьдчилсан мэдээ, байгалийн гамшигт үзэгдлийн тухай урьдчилсан мэдээг дор дурдсан хуваарийн дагуу Монголын үндэсний радио, телевизээр тогтмол дамжуулж байхаар тогтсугай:

а/радиогаар дамжуулах тухайн өдрийн мэдээг өглөөний 6 цаг 40 минут, 9 цаг 10 минутаас өдөр бүр; хоногийн болон тав, долоо хоногийн урьдчилсан мэдээг 15 цаг 10 минут, 17 цаг 10 минут, 19 цаг 10 минут, 21 цаг 30 минутаас өдөр бүр; сар, улирлын урьдчилсан мэдээг өмнөх сарын 23-ны өдрийн 15 цаг 10 минутаас;

б/телевизээр дамжуулах тухайн өдрийн мэдээг өглөөний 9 цаг 10 минутаас өдөр бүр; хоногийн болон тав, долоо хоногийн урьдчилсан мэдээг 19 цаг 10 минут, 21 цаг 30 минут, 22 цаг 50 минутаас өдөр бүр; сар,

улирлын урьдчилсан мэдээг өмнөх сарын 23, 30-ны өдрийн 21 цаг 30 минутаас; в/байгаль, цаг уурын гэнэтийн гамшигт үзэгдэл болох тухай урьдчилан сэргийлэх шуурхай мэдээг тухай бүрт нь.

2.Цаг агаарын өдрийн мэдээ, урьдчилсан болон урьдчилан сэргийлэх мэдээ, орчны бохирдол, усны үер, ой, хээрийн түймрийн тухай мэдээллийг орон нутагт шуурхай дамжуулах нөхцөл, болзлыг гэрээнд тусгуулсны үндсэн дээр телевиз, радиогийн долгион эзэмших зөвшөөрөл олгож байхыг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүүд даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** Р.АМАРЖАРГАЛ

**Байгаль орчны сайд** С.МЭНДСАЙХАН  
**Дэд бүтцийн хөгжлийн сайд** Г.БАТХҮҮ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 2 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хувь этгээдээс хураан төвлөрүүлэх журам"-ыг хавсралтын ёсоор баталж, уг асуудлыг хуулиар зохицуулах хүртэл хугацаанд түр мөрдүүлсүгэй.

2.Энэ журмын дагуу айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хувь этгээдээс телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэн хурааж, зохих хэсгийг Монголын үндэсний телевизийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулахыг Монголын үндэсний радио, телевизэд зөвшөөрсүгэй.

3. Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг Монголын үндэсний телевизийн төсөвт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт оруулан тооцож байхыг Сангийн сайд

Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

**Монгол Улсын  
Ерөнхий сайд**

**Р.АМАРЖАРГАЛ**

**Дэд бүтцийн  
хөгжлийн сайд**

**Г.БАТХҮҮ**

Засгийн газрын 2000 оны 28 дугаар  
тогтоолын хавсралт

## ТЕЛЕВИЗИЙН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ АЙЛ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ХУВЬ ЭТГЭЭДЭЭС ХУРААН ТӨВЛӨРҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү дүрмийн зорилго нь телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний чанараас хамааруулан телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, үйлчилгээний хөлсийг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хувь этгээдээс хураан авч төвлөрүүлэх, телевизийн нэвтрүүлгийг кабелийн болон бусад телевизээр давтан дамжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Телевизийн үйлчилгээний хөлсийг авах үндэслэл

2. Оюуны өмч болох уран бүтээл, телевизийн нэвтрүүлэг зэргийг бүтээж, мэдээллийг олон нийтийн хүртээл болгож байгаа үйл ажиллагаа нь телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг авах үндэслэл болно.

3. Үйлчилгээний хөлс нь телевизийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардлыг санхүүжүүлэхэд зориулна.

### Гурав. Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох

4. Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс тогтооход хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-ийг ажиллуулна.

5. Телевизийн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах зардлыг нэгж телевизийн хүлээн авах цэгт бүрэн ногдуулан тооцно.

6. Зөвлөл нь холбогдох байгууллагаас санал авсны үндсэн дээр телевизийн үйлчилгээний чанарыг харгалзан телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтооно.

7. Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэхэд гарсан зардлыг нийт төвлөрүүлсэн үйлчилгээний хөлснөөс тухай бүр суутган тооцсоны дараа үлдэх хэсгийн 70 хувийг Монголын үндэсний телевизэд, 10 хувийг "Улаанбаатар" телевизэд, 10 хувийг "MN-25 дугаар суваг" телевизэд, 10 хувийг "Ийгл" телевизэд тус тус хуваарилна.

8. Бусад телевизийн нэвтрүүлгийг дамжуулан нэвтрүүлэх сонирхол бүхий кабелийн телевиз уг нэвтрүүлгийг бэлтгэсэн телевизтэйгэрээ байгуулан нэвтрүүлгийг нь дамжуулах эрхийг шилжүүлэн авч болно.

9. Сонин, сэтгүүл нь гэрээ байгуулсны үндсэн дээр телевизийн нэвтрүүлгийн хөтөлбөрийг хэвлэн нийтэлнэ.

### Дөрөв. Үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх

10. Монголын үндэсний телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний чанарт хяналт тавих, телевизийн үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх эрх бүхий Хяналт, маркетингийн албыг Монголын үндэсний радио, телевизэд ажиллуулна.





11. Хяналт, маркетингийн албаны дотоод дүрэм, орон тоо, зохион байгуулалтыг Зөвлөл батална.

12. Хяналт, маркетингийн алба нь бусад телевизтэй гэрээ байгуулсны үндсэн дээр телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг төвлөрүүлж хуваарилна.

13. Хяналт, маркетингийн албаны жилийн төсөвт зардал, орлогын төлөвлөгөөг Монголын үндэсний радио, телевизийн төсвийн төсөлд тусган батлуулна.

**Тав. Журам зөрчигчдөд хүлээлгэх**

### хариуцлага.

14. Монголын үндэсний телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд нь төлөөгүй айл өрх, албан байгууллагад болон Монголын үндэсний телевиз, бусад телевизийн нэвтрүүлгийг зохих журмын дагуу гэрээ байгуулж, зөвшөөрөл аваагүй дамжуулсан кабелийн телевиз, бусад телевизэд Захиргааны хариуцлагын тухай болон Зохиогчийн эрхийн тухай хуулинд заасан захиргааны шийтгэл ногдуулна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 2 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

### Химийн бодисын аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай

Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Химийн бодисын ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэлийг сайжруулан журамлах, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх, химийн бодисын тухай улсын хэмжээний нэгдсэн сан бүрдүүлэх шаардлагыг харгалзан химийн бодисын улсын үзлэг, тооллогыг 2000 оноос эхлэн хоёр жил тутам явуулж байхаар тогтоосугай.

2. Байгаль орчны сайд бөгөөд Химийн бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга С.Мэндсайхан, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонин нарт даалгах нь:

а/бэлтгэлийг урьдчилан хангасны үндсэн дээр химийн бодисын улсын үзлэг, тооллогыг хугацаанд нь зохион байгуулан явуулж, түүний дүн болон үзлэгийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тооллого хийсэн тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт танилцуулж байсугай;

б/химийн бодис, тэдгээрийн зарцуулалтыг бүртгэх болон улсын үзлэг, тооллого явуулах маягт, хөтлөх аргачилсан зааврыг 2000 оны эхний хагас жилд багтаан баталж орон нутагт хүргүүлэх, химийн хурц болон архаг хордлогыг бүртгэх анхан шатны маягтыг боловсронгуй болгох арга хэмжээ авсугай;

в/химийн бодис үйлдвэрлэх, импортлох, хэрэглэхэд хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, хордлогын үед шаардлагатай эрүүл мэндийн тусламж үзүүлэх үйлчилгээг эрчимжүүлэх, хордлогын шалтгааныг богино хугацаанд судлан тогтоож нийтэд мэдээлэх арга хэмжээ авч байсугай, г/сургалт, семинар зохион байгуулах, гарын авлага, зааварчилгаар хангах замаар аймаг, нийслэлийн химийн бодисын улсын үзлэг, тооллогын комиссын ажлын бэлтгэлийг тооллого явуулах тухайн жилийн I улиралд багтаан хангуулж байсугай;

д/химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг саармагжуулах, хоргүйжүүлэх, химийн бодисын хаягдлыг устгах төрөлжсөн цэг байгуулах аргачлал, заавар боловсруулан гаргаж мөрдүүлэх асуудлыг Улсын иргэний хамгаалалтын газартай, химийн онцгой хортой болон онцгой аюултай бодис хадгалах гаалийн баталгаат агуулах бий болгох асуудлыг Улсын гаалийн ерөнхий газартай тус тус хамтран судалж, хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай;

е/химийн хорт бодисын хаягдал болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн хорт бодисыг устгах цэгийг 2000 оны II улиралд багтаан аймаг, нийслэлд тогтоож өгөх арга хэмжээ авсугай.

3. Химийн бодисын улсын үзлэг, тооллого явуулахад шаардагдах зардлыг 2002 оноос эхлэн тухайн жилийн байгаль орчны төвлөрсөн арга хэмжээний төсөвт, химийн хорт

болон аюултай бодисын тухай мэдээллийн сангийн нэгдсэн сүлжээ байгуулах, химийн бодисын бохирдол, хор аюулын зэргийг тодорхойлох техник-технологийг шинэчлэхэд шаардагдах хөрөнгийг 2001 оноос эхлэн улсын төвлөрсөн төсөвт тус тус тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

4.Батлан хамгаалахын сайд бөгөөд Улсын байнгын онцгой комиссын дарга Ш.Түвдэндорж, Байгаль орчны сайд бөгөөд Химийн бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга С.Мэндсайхан нарт даалгах нь:

а/химийн хорт болон аюултай бодис ашиглаж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тохиолдож болзошгүй аюулыг тодорхойлох, үнэлгээ хийх болон химийн бодисын хор аюулын тухай лавлагааны материал бэлтгэж нийтийн хүртээл болгох арга хэмжээ авч байсугай;

б/химийн бодисын улсын үзлэг, тооллогод зэвсэгт хүчний анги, салбарын химийн албаны дарга, мэргэжилтнийг татан оролцуулах арга хэмжээ авч байсугай.

5.Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/Байгаль орчны болон Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамтай бүрэлдэхүүнийг нь зөвшилцсөний үндсэн дээр химийн бодисын улсын үзлэг, тооллогын

комиссыг тооллого явуулах тухайн жилийн I сард багтаан томилж байсугай;

б/химийн бодисын улсын үзлэг, тооллого явуулах ажлыг зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн бүрээр ашиглаж буй химийн бодис, тэдгээрийн зарцуулалтын бүртгэлийг хөтлүүлэх, химийн бодисын шинж чанар болон хор аюулын тухай лавлагаа бүрдүүлэх ажлыг тогтмол хийлгэж хэрэгжилтэд нь байнга хяналт тавьж байсугай;

в/Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих асуудлыг мэргэжлийн хяналтын албаны аль нэгэн ажилтны ажлын байрны тодорхойлолтод нэмж тусгуулах замаар зохицуулан шийдвэрлэх арга хэмжээ авсугай.

6.Улсын хилээр нэвтэрч байгаа химийн хорт болон аюултай бодисын тухай дэлгэрэнгүй мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал тутам гарган өгч байхыг Улсын гаалийн ерөнхий газрын дарга Т.Лхагваад даалгасугай.

**Монгол Улсын**

**Ерөнхий сайд**

**Байгаль орчны сайд**

**Р.АМАРЖАРГАЛ**

**С.МЭНДСАЙХАН**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 2 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

### Орон нутгийн мэргэжлийн хяналтын албадын талаар авах зарим арга хэмжээний тухай

Орон нутагт ажиллаж буй мэргэжлийн хяналтын албадын хяналт шалгалтын ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймгийн мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрмийг 1 дүгээр хавсралтаар, мэргэжлийн хяналтын албанд ажиллах улсын байцаагчдын жишиг тоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын албадын үйл ажиллагааг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Сангийн сайд Я.Очирсүх, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Аймгийн Засаг дарга нарт даалгах нь:

а/аймаг, орон нутагт стандарт чанарын баталгаажуулалт, эрүүл ахуйн чиглэлээр ажиллаж буй лабораториудыг мэргэжлийн хяналтын албаны дэргэд нэгтгэн зохион байгуулж, техник хэрэгсэл, эм урвалжаар хангах арга хэмжээ авч ажилласугай;

б/мэргэжлийн хяналтын албанаас зохиосон ажил, түүний дүнг улирал тутам хэлэлцэж, ажилд нь байнгын дэмжлэг туслалцаа үзүүлж байсугай;

в/мэргэжлийн хяналтын албанд ажиллаж буй улсын ахлах болон улсын байцаагчийн цалинг "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 94 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл"-д заасан ТЗ-7, ТЗ-6-гийн "улсын ахлах байцаагч", "улсын байцаагч" гэсэн зэрэглэлд хамруулсугай.

4. Орон нутагт ажиллаж буй мэргэжлийн хяналтын албадыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж улсын байцаагчийн мэргэшлийг дээшлүүлэх, гадаад, дотоодын сургалт, семинарт оролцуулж байхыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Төсөвт зардал хэмнэх, шат дамжлагыг багасгах, улсын байцаагчийн ажлын ачааллыг жигд байлгах зорилгоор ажилтнуудаа мэргэшүүлэх замаар зарим улсын байцаагчдын ажлыг хууль тогтоомжоор хориглоогүй бол хавсран гүйцэтгүүлж байх арга хэмжээ авч байхыг аймгийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

6. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Н.Батбаярт даалгах нь:

а/мэргэжлийн хяналтын агентлагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, тэдний хийсэн ажлын тайланг жил бүрийн I улиралд авч хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч байсугай;

б/бараа, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдалд тавих хяналтын чиглэлээр давхацсан үйл ажиллагаа явуулж буй агентлагуудын давхардлыг арилгах санал боловсруулж 2000 оны I улиралд танилцуулсугай.

Монгол Улсын  
Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Хууль зүйн сайд бөгөөд  
Сангийн сайдын үүрэг  
гүйцэтгэгч

Д.ГАНБОЛД

Засгийн газрын 2000 оны 31 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН АЛБАНЫ НИЙТЛЭГ ДҮРЭМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.Аймгийн мэргэжлийн хяналтын алба /цаашид "хяналтын алба" гэх/ нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, Засаг даргын захирамж болон эрх бүхий дээд байгууллагаас баталсан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын байцаагчийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий аймгийн Засаг даргын бодлого хэрэгжүүлэх чиг үүрэгтэй захиргааны хяналтын байгууллага юм.

2.Хяналтын алба нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3.Хяналтын алба нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх зарчмыг баримтална.

4.Хяналтын алба нь хяналт шалгалтын ажлыг чиг үүргийнхээ хүрээнд байгууллагын харьяалал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр графикт төлөвлөгөө, төв, орон нутгийн удирдах байгууллагын даалгавар, иргэдийн мэдээлэл болон холбогдох санал, гомдлыг үндэслэн явуулж дүгнэлт гаргана.

5.Хяналтын алба нь байр, унаа, техник хэрэгслээр хангагдсан, хөндлөнгийн хяналт байхаар зохион байгуулагдан холбогдох сайд, Засаг даргын өмнө ажлаа хариуцна.

6.Төрийн захиргааны төв болон нутгийн

захиргааны байгууллага нь хяналтын албаны үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж, шаардлагатай техник хэрэгсэл, мэдээллээр ханган холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах үүрэгтэй байна.

7.Хяналтын алба нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### Хоёр.Хяналтын албаны удирдлага, зохион байгуулалт

8.Хяналтын албаны даргыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө. Албаны даргаар улсын ахлах байцаагчийг ажиллуулна.

9.Хяналтын албанд улсын ахлах байцаагч болон улсын байцаагч ажиллана. Улсын ахлах болон улсын байцаагчийг албаны даргын саналыг үндэслэн тухайн салбарын ерөнхий байцаагчтай зөвшилцөн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг холбогдох сайд олгоно.

10.Хяналтын алба нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, улсын байцаагчаас бүрдсэн орон тооны бус зөвлөлтэй байж болно. Зөвлөлийг Засаг даргын захирамжаар байгуулна.

### Гурав.Хяналтын албаны үүрэг

11.Хяналтын алба нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр болон Засаг даргын захирамж, эрх бүхий байгууллагаас баталсан журам, дүрмийн биелэлтийг нутгийн захиргааны байгууллага болон өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжид шалгаж гүйцэтгэлийг хангуулах;

б/нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн чиг үүргийн хэрэгжилт, албан тушаалтны үндсэн үүргийн биелэлтийг ажлын хариуцлага, сахилгатай нь холбон шалгаж зөрчлийг арилгуулах;

в/үндсэн үүргээ биелүүлээгүй, гэм буруутай болох нь шалгалтаар нотлогдсон албан тушаалтанд хуульд заасан шийтгэл ногдуулах санал тавих, эрүүгийн гэмт хэргийн шинжтэй болох нь илэрсэн тохиолдолд холбогдох материалыг хуулийн зохих байгууллагад шилжүүлэх;

г/хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр зөрчсөн букуу биелүүлээгүйгээс улсад учруулсан хохирлыг нөхөн тооцож улс, орон нутгийн төсвийн орлогод оруулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлж биелэлтийг хангуулах;

д/шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаархи саналаа зохих дээд шатны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх;

е/хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар авсан арга хэмжээ, хийгдсэн ажлын дүнг аймаг, нийслэлийн Засаг даргад тогтмол мэдээлж, улсын байцаагчдын хийсэн ажлын тайланг тогтоосон хугацаанд нь агентлагуудад гаргуулан өгч байх;

ж/төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг байгууллага, иргэдэд мэдээлж, сурталчилж

байх;

з/шалгалтаар илэрсэн зөрчил, авсан арга хэмжээнийхээ талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж байх.

## Дөрөв.Хяналтын албаны эрх

12.Хяналтын алба нь дор дурдсан эрх эдэлнэ;

а/улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

б/шаардлагатай мэдээ, судалгаа, холбогдох бусад баримт материалыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан тушаалтнаас гаргуулан авах;

в/шаардлагатай үед Засгийн газрын тохируулагч агентлаг, улсын байцаагчаар шалгалт, шинжилгээ хийлгэх санал тавих;

г/хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

д/хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчилтэй холбогдуулан гэм буруутай байгууллагын албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;

е/улсын байцаагчийн ажлыг дүгнэх, шагнаж урамшуулах, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах;

ж/захиргааны хяналтыг хэрэгжүүлэхдээ нутаг дэвсгэртээ байгаа тухайн салбарын мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж хяналт шалгалтын ажилд татан оролцуулж болно.





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 3 дугаар  
арын 1-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар  
хот

### Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ  
нь:

1. "Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, сөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулан хяналт тавьж эжиллахыг зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүйн сайд Д.Ганболдод даалгасугай.

3. Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг өөрийн хариуцсан салбартаа зохион байгуулахыг холбогдох сайд, Засгийн газрын агентлагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нэрт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын  
үүрэг гүйцэтгэгч бөгөөд

Сангийн сайд

Я.ОЧИРСҮХ

Хууль зүйн сайд

Д.ГАНБОЛД

Засгийн газрын 2000 оны 34 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### ХАР ТАМХИ, МАНСУУРАЛТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

#### Нэг.Хөтөлбөрийн үндэслэл

Манай оронд сүүлийн жилүүдэд хар тамхи, мансууруулах төрлийн бодис олж авах, хэрэглэх, боловсруулах, зарж борлуулах явдал өсч, улмаар үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, иргэдийн хэвийн амьдралд бодит бэрхшээл учруулж болзошгүй байна.

Хар тамхи, мансууруулах төрлийн бодис олж авах, хэрэглэх, боловсруулах, борлуулах гэмт хэрэг өсөхөд дараахь хүчин зүйл сөргөөр нөлөөлж байна:

-зэрлэг олсны /каннабис/ ургамал нь Орхон, Сэлэнгэ, Дархан-уул аймаг болон Дорнод аймгийн Халх гол сум, Ховд аймгийн Булган, Үенч сумын нутгаар нилээд тархмал ургадаг аас тэдгээрийг авч ашиглахад хялбар бэлэн байдаг;

-энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий төв, орон нутгийн хууль хяналт, эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын ажилтан, албан хаагчид хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл, тархалтын талаар нэгдсэн ойлголтгүй байна;

-хар тамхи, мансуурлыг сурталчилсан ном сэтгүүл, видео кино гарах болсон;

-хар тамхи, мансууруулах төрлийн бодисыг хэрэглэх, түүж боловсруулах, борлуулах гэмт хэрэг нарийн зохион байгуу-

лалттай болж байна;

-эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа зарим аж ахуйн нэгж, байгууллага мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй эм бодисыг хяналт зөвшөөрөлгүй ашиглаж байна;

-хар тамхи, мансууруулах төрлийн бодис бэлтгэсэн, борлуулсан гэмт хэрэг үйлдэгчдэд олонхи тохиолдолд торгох ял ногдуулж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг давтан үйлдэх бололцоо олгож байна;

-хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх ажил улсын хэмжээнд нэгдсэн бодлого чиглэлгүй байна;

Иймээс манай улсад хар тамхи, мансуурлын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг тодорхой чиглэл, зорилготой, тусгай төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулах шаардлага гарч байна.

#### Хоёр.Хөтөлбөрийн зорилт

Энэхүү Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зорилтыг шийдвэрлэнэ:

1.Хар тамхи, мансууралтай тэмцэхэд төр, засаг, нутгийн захиргаа, өөрөө удирдах ёсны байгууллагын бодлого, үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх

2. Хар тамхи, мансууруулах бодис олж авах, хадгалах, хэрэглэх, боловсруулах, худалдан борлуулах төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх

3. Хар тамхи, мансуурлын гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөлийг судлах, түүнтэй гэмцэх бодлого боловсруулах

4. Хууль хяналтын болон шүүх эрх мэдлийн байгууллагын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлж хар тамхи, мансууралтай холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого чиглэлтэй ажиллах

5. Нийт иргэд, хүүхэд залуучуудад хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг, сөрөг үр дагаврыг тайлбарлан таниулж байгуулан идэвхжүүлж хар тамхи, мансууралтай холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого чиглэлтэй ажиллах

6. Хар тамхи, мансуурах төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар холбогдох байгууллага, жилтны дунд семинар, зөвлөлгөөн, онол практикийн бага хурал зохион байгуулж энэ жилд гарч байгаа хүндрэл бэрхшээл, сөрөг үр дагавар зэргийг судлан эрх зүйн болон практик ажиллагааны зорилтыг тодорхойлж зайх

7. Эрүүгийн болон Эмийн тухай Монгол Улсын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг тухай бүр боловсруулан шийдвэрлүүлэх

8. Хар тамхи, мансууруулах бодисыг таньж илрүүлэх үүрэг бүхий шинжилгээний лабораториудыг техник хэрэгсэл, эргэлжилтэй боловсон хүчнээр хангах.

## Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, ажиллагаа

1. Улсын хэмжээнд хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулж, хяналт тавих ажлыг Хар тамхи, мансууралтай тэмцэх орон ооны бус Үндэсний зөвлөл хариуцна.

2. Үндэсний зөвлөл хар тамхи, мансууралтай тэмцэх ажлын явц, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаархи мэдээ, айланг улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж, жил үүр Засгийн газарт танилцуулна.

3. Аймаг, нийслэлд Хар тамхи, мансууралтай тэмцэх салбар зөвлөл ажиллах бөгөөд уг салбар зөвлөлийг тухайн Засаг дарга тэргүүлнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид батална.

4. Үндэсний зөвлөл болон аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн ажиллах журмыг Хууль зүйн сайд батална.

5. Салбар зөвлөл нь аймаг, нийслэлийн хэмжээнд хар тамхи, мансууралтай тэмцэх төлөвлөгөө боловсруулан, тухайн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулна.

6. Салбар зөвлөл нь энэхүү Хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулан, хяналт тавьж ажиллана.

7. Хар тамхи, мансууралтай тэмцэх аймаг, нийслэлийн салбар зөвлөл нь энэхүү Хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам гаргаж Үндэсний зөвлөлд хүргүүлнэ.

8. Үндэсний зөвлөл нь энэ Хөтөлбөр болон хар тамхи, мансууралтай тэмцэх талаар төр, засгаас явуулж буй бодлогыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч яам, агентлаг, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан хамтарч ажиллана.

9. Яам, агентлаг өөрийн үйл ажиллагааны хүрээнд хар тамхи, мансууруулах бодистой холбогдолтой гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж болон энэхүү Хөтөлбөрийн биелэлтийг хангах арга хэмжээ авч, зохиосон ажлын явц, үр дүнг Үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна.

10. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Засгийн газар, холбогдох яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага дараахь үүрэгтэйгээр ажиллана. Үүнд:

1/Засгийн газар:

а/Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвтэй уялдуулах;

б/хар тамхи, мансууруулах бодисыг таньж илрүүлэх, шинжлэх багаж, хэрэгслийг импортлоход татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх;





в/Хөтөлбөрт тусгагдсан хар тамхи, мансууралтай тэмцэх чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх сургалтын зардал, түүнчлэн хар тамхи, мансууруулах бодисыг шинжлэх багаж хэрэгслээр хангах талаар тодорхой төсөл сонгон шалгаруулж санхүүжүүлэх;

г/хар тамхи, мансууруулах бодисын тухай улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан байгуулах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцдэг байгууллага хоорондын мэдээллийн сүлжээ бий болгох;

д/хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх талаар НҮБ болон бусад олон улсын байгууллагын баталсан гэрээ конвенцид нэгдэн орох асуудлыг судлан шийдвэрлүүлэх.

2/Хууль зүйн яам:

а/хар тамхи, мансууралтай тэмцэх Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, бусад яам, агентлаг, хууль хяналт, нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийг энэ ажилд оролцуулах;

б/хар тамхи, мансуурлын гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаархи хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах, хор уршгийн талаар мэдээлэх;

в/хар тамхи, мансуурлын гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хууль хяналт, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулах;

г/хар тамхи, мансууралтай тэмцэх ажлын үр дүнг дээшлүүлэх, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

д/гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хар тамхи, мансууралтай тэмцэх талаар холбогдох олон улсын байгууллага, гадаад оронтой хамтран ажиллах.

3/Гэгээрлийн яам:

а/хүүхэд, залуучууд, иргэдийг хар тамхи, мансуурлын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар бүх шатны сургуулийн сургалтын программд тусгах;

б/хүүхэд, залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр гарсан үүсгэл санаачилгыг дэмжих;

в/ерөнхий боловсролын сургууль, тусгай мэргэжлийн коллеж, их, дээд сургуулиудын оюутан, сурагчдын дунд хар тамхи, мансуурах төрлийн гэмт хэргийн талаар холбогдох судалгаа хийж, дүгнэлт гарган урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах;

г/хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийг харуулсан урлагийн бүтээл, нийтлэл, нэвтрүүлгийг олшруулах бодлого баримтлах;

д/Монгол оронд ургаж буй мансууруулах төрлийн ургамлын тархац, төрөл, нутагшилтыг судлан тогтоож, түүнтэй тэмцэх талаар хууль сахиулах холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах.

4/Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам:

а/хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийг арилгах, эмчлэн сэргээх, урьдчилан сэргийлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

б/мансуурах донтой өвчтөнийг эмчлэн сэргээх, мансуурлын зэрэг, хувь хэмжээг тогтоох аргачлалыг боловсронгуй болгох;

в/мансуурлын хор уршгийг олон нийтэд таниулах /плакат зураг, гарын авлага бэлтгэх, тараах/;

г/сэтгэц нөлөөт болон мансууруулах үйлчилгээтэй эм бэлдмэлийн талаар гарах журмыг тухай бүр шинэчлэн боловсруулж, хяналт тавих;

д/хар тамхи, мансууруулах бодисын болон мансуурлыг тодорхойлох багаж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн ажилтныг давтан сургах, дадлагажуулах.

5/ Улсын гаалийн ерөнхий газар:

а/мансууруулах бодис болон сэтгэц нөлөөт бодисыг Монгол Улсын хилээр оруулж, гаргахад хяналт тавих бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

б/химийн утгаар болон сэтгэц нөлөөт бодист тавих хяналтын талаар Монгол Улсын Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, түүний хөдөлгөөнд хяналт тавих, харилцан мэдээлэх сүлжээ бий болгох;

в/хар тамхи, мансууруулах болон сэтгэц нөлөөт бодисыг илрүүлэх, таних, шинжлэх хураан авах арга зүйд ажилтнаа сургах, холбогдох техник хэрэгсэл, үнэрч нохой зэргээр хангах.

6/Цагдаагийн ерөнхий газар:

а/хар тамхи, мансууруулах бодис олж авах, хадгалах, хэрэглэх, боловсруулах бусад худалдан борлуулахтай холбогдох хэрэг, зөрчлийг илрүүлэх, мөрдөн шалгах түүний шалтгаан нөхцөлийг арилгуулахад байнга анхаарч ажиллах;

б/хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын явцын тухай мэдээ, тайланг улсын хэмжээнд жил тутай нэгтгэн дүгнэлт хийж Үндэсний зөвлөлд танилцуулж байх;



в/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шатны ажлын төлөвлөгөөний биелэлт, цаашид авах арга хэмжээг төлөвлөн тухай бүр Үндэсний зөвлөлд танилцуулж ажиллах;

г/хар тамхи болон мансууруулах төрлийн ургамал, бодисыг илрүүлэх, ялгаж чиглэлээр хууль хяналтын байгууллагуудын ажилтнуудад сургалт зохион байгуулах;

д/хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх үүрэг бүхий цагдаагийн байгууллагын ажилтны мэргэжлийн ур чадвар, дадлагыг дээшлүүлэх;

е/Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам сэдвээр эрдэм шинжилгээний бага хурал, ярилцлагыг зохион байгуулж, хар тамхи, мансууралтай тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал гаргах.

ажиллах;

г/хар тамхи, мансууруулах бодисын холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй ажил зохиож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний урамшуулах, арга туршлагыг нь дэлгэрүүлэх.

## Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт

1.Хар тамхи, мансууруулах бодисын холбогдолтой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

2.Хар тамхи, мансуурлын гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Цагдаагийн ерөнхий газрын жил бүрийн төсөвт тусгана.

3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллагуудын хандив, тусламж болон бусад нөөц бололцоог ашиглан хар тамхи, мансууралтай холбогдсон гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Үндэсний зөвлөл, аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн дэргэд сан байгуулж энэхүү Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулж болно.

7/Тагнуулын ерөнхий газар:

а/энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг тухай бүр илрүүлж, мөрдөн шалгах, түүний шалтгаан нөхцөлийг илрүүлж арилгуулах, урьдчилан сэргийлэх ажлыг идэвхжүүлэх;

б/Монгол Улсын хил залгаа орнуудад гарч байгаа хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаархи мэдээллээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг хангах;

в/гэмт хэрэгтэн Монгол Улсад хууль бусаар орох, тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх талаархи гэмт хэргийн мэдээлэл солилцож, хууль хяналтын бусад байгууллагатай хамтран ажиллах.

## Тав.Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, үе шат, үр дүн

1.Үндэсний хөтөлбөрийг 2000-2005 онд хэрэгжүүлнэ.

2.Энэ Хөтөлбөрийг 2000-2002, 2003-2005 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Нагдугаар үе шат 2000 онд Үндэсний хөтөлбөрийг төв, орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, бүх шатанд үе ажлыг жигд эхлүүлж, энэ төрлийн гэмт хэрэг их гардаг аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж эхэлнэ.

2001-2002 онд хар тамхи, мансууралтай тэмцэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, тэмцлийн аргыг шинэчлэн тодорхойлж, боловсронгуй болгох, энэ талаар зохиох ажлыг тогтмолжуулна. Цагдаагийн болон хил, гаалийн албаны ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгон, ажилтнуудыг сургаж мэргэшүүлэх, техник хэрэгслээр хангах талаар тодорхой арга хэмжээ авна.

2000-2002 онд хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийг тайлбарлан таниулах, сурталчлах ажилд мэдэгдэхүйц ахиц гаргана.

Хоёрдугаар үе шат 2003-2005 онд Үндэсний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлснээр хар тамхи, мансууруулах төрлийн гэмт хэргийн өсөлтийг сааруулна.

Хар тамхи, мансууруулах бодисын холбогдолтой гэмт хэрэгтэй тэмцэх гол нөхцөл болсон холбоо, техник хэрэгсэл, мэдээллийн бааз суурийг бэхжүүлнэ. Иргэд, хүүхэд, залуучуудыг эрүүл нийгэмд амгалан тайван аж төрөх нөхцөлийг хангаж улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэргийн өсөлтийг бууруулж, цаашид түүнээс урьдчилан сэргийлэх бүх талын нөхцөлийг бүрдүүлнэ.

3.Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний үе шатны төлөвлөгөөг Засгийн газар батална. Энэ төлөвлөгөөг үндэсний Үндэсний зөвлөл жил бүр төлөвлөгөөтэй ажиллана.

8/Хэвлэл мэдээллийн байгууллагууд:

а/үндэсний болон орон нутгийн хэвлэлийн нийтлэл, радио, телевизийн нэвтрүүлгийн хөтөлбөрт мансуурлаас урьдчилан сэргийлэх сэдэв, зар сурталчилгааг нэмэгдүүлэх;

б/хүүхэд, залуучууд, иргэдийг хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс сэргэмжлүүлэх зорилгоор цуврал сурталчилгаа хийж байх.

9/Төрийн бус байгууллагууд:

а/төрөөс хар тамхи, мансуурлын эсрэг баримталж буй бодлогыг дэмжих, энэ чиглэлээр төв, орон нутгийн хууль хяналт, эрүүл мэнд, боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах;

б/хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар бусад байгууллагуудаас зохиож буй ажилд идэвхтэй оролцож, дэмжлэг тусалцаа үзүүлэх.

10/Гэр бүл, иргэдийн оролцоо

а/үр хүүхэд, гэр бүлийнхээ гишүүдэд хар тамхи, мансуурах бодисын хор хөнөөлийг ойлгуулах, уламжлалт зан заншил, хүмүүжлийг төлөвшүүлэх;

б/төр, засгаас мансуурлын эсрэг гаргасан хууль тогтоомжийг чанд биелүүлэх.

11/Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар

а/хар тамхи, мансууралтай тэмцэх Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тухайн нутаг дэвсгэрийнхээ онцлогт тохирсон ажлын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;

б/нутаг дэвсгэртээ хар тамхи, мансууруулах бодистой холбогдолтой хэргийн байдалд судалгаа хийж, түүний шалтгаан нөхцөлийг илрүүлж, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

в/хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг хил залгаа аймагтай хамтран явуулах, энэ ажилд хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог өргөтгөхөд байнга анхаарч

Засгийн газрын 2000 оны 34 дүгээр тогтоолын  
2 дугаар хавсралт

## ХАР ТАМХИ, МАНСУУРАЛТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ 2000-2002 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хийх ажил	Гүйцэтгэх хугацаа	Хариуцах байгууллага
1	2	3
Нэг. Төр, захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын хүрээнд		
1. "Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн биелэлтийг зохион байгуулж, хяналт тавих үүрэг бүхий зөвлөлийг ажиллуулах 2. "Хар тамхи, мансууралтай холбоотой гэмт хэргийн гаралт, тархалт, түүний шалтгаан нөхцөл, тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх эрх зүйн болон практик ажиллагааны үндэслэлийг боловсруулах	2000 оны I улиралд  2000 оны II улиралд	Хууль зүйн яам Цагдаагийн ерөнхий газар  Үндэсний зөвлөл Хууль зүйн яам Цагдаагийн ерөнхий газар Тагнуулын ерөнхий газар Улсын гаалийн ерөнхий газар
3. Хар тамхи, мансууралтай тэмцэх ажил үүргийг эрүүгийн төлөөлөгчдөд хариуцуулж, цагдаагийн болон Тагнуулын ерөнхий газрын алба хаагчдад дэс дараатай сургалтуудыг зохион байгуулах	2000 оноос	Цагдаагийн ерөнхий газар Тагнуулын ерөнхий газар
4. Хөгжингүй орнуудад хар тамхи, мансууруулах бодистой төлөрхөй байгаа арга туршлагыг судлах, энэхүү чиглэлээр тодорхой тооны ажилтнуудыг сургах ажлыг зохион байгуулах	2000 оноос	Хууль зүйн яам Цагдаагийн ерөнхий газар Улсын гаалийн ерөнхий газар Тагнуулын ерөнхий газар
5. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хар тамхи, мансууралтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох	2000 оноос	Үндэсний зөвлөл, Хууль зүйн яам Цагдаагийн ерөнхий газар Тагнуулын ерөнхий газар

1	2	3
6. Улсын хэмжээнд хар тамхи, мансууралтай холбогдох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхэд, залуучууд, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан зөвлөмж, мэдээлэл сэрэмжлүүлэг боловсруулан хэвлүүлж хүргүүлэх, сурталчилгаа зохион байгуулах	2000 оноос	Үндэсний зөвлөл Цагдаагийн ерөнхий газар Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам Гэгээрлийн яам Тагнуулын ерөнхий газар Улсын гаалийн ерөнхий газар Хэвлэл мэдээллийн байгууллага
7. Хар тамхи, мансууруулах бодисын холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн уран бүтээлийн уралдаан зарлан дүгнэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	2000 оноос	Цагдаагийн ерөнхий газар Радио, телевизийн байгууллага Гэгээрлийн яам
8. Криминалистик шинжилгээний болон сэтгэцийн эмгэг наркологийн төвийн техник, багаж төхөөрөмжийг шинэчлэх, холбогдох материалаар хангах асуудлыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх	2000 оны П улирлаас	Үндэсний зөвлөл Хууль зүйн яам Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам Цагдаагийн ерөнхий газар
9. Хар тамхи, мансууруулах төрлийн бодисыг шинжлэх, таних, судлах, илрүүлэх, аюулгүй болгох талаар мэргэжсэн боловсон хүчинтэй болох	2000 оны П улирлаас	Үндэсний зөвлөл Хууль зүйн яам Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам Цагдаагийн ерөнхий газар Улсын гаалийн ерөнхий газар Тагнуулын ерөнхий газар
10. Хар тамхи, мансууруулах төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий албадыг машин унаа, тусгай техник хэрэгслээр хангах, цагдаагийн төв, орон нутгийн газар, хэлтэс болон хил, гааль, хууль хяналтын бусад байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн сүлжээтэй болгох	2001 оноос	Үндэсний зөвлөл Хууль зүйн яам Цагдаагийн ерөнхий газар Улсын гаалийн ерөнхий газар Тагнуулын ерөнхий газар
11. Хар тамхи, мансууруулах бодисын холбоотой гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн тэнсэн болон хянан харгалзах ялтай этгээдүүдийг захиргааны хяналтад авах журмыг боловсронгуй болгох	2000 оны IV улиралд	Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам Цагдаагийн ерөнхий газар

1	2	3
12. Хар тамхи, мансуурахтай холбогдсон гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын арга зүйг боловсруулах 13. Мансууруулах бодисын хууль бус эргэлтийн тухай 1988 оны Венийн конвенцид нэгдэх асуудлыг судалж холбогдох дээд байгууллагад тавих	2000 оноос  2000 оны II улиралд	Хууль зүйн яам Цагдаагийн ерөнхий газар Татнуулын ерөнхий газар  Үндэсний зөвлөл Хууль зүйн яам Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам
Хоёр. Нийгэм, эдийн засгийн хүрээнд  1. Ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургууль, коллеж, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийн талаар тусган хэрэгжүүлж эхлэх 2. Хар тамхи, мансууруулах төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд төрийн бус байгууллагыг татан оролцуулах, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих 3. Хар тамхи, мансууралтай хийх тэмцлийг сайжруулах, түүний санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байх 4. Эзрлэг олсны ургамал ургадаг бус нутагт судалгаа хийсний үндсэн дээр устгал хийх	2000-2001 оны хичээлийн жилээс  2000 оноос  2000 оноос  2000 оноос	Гэгээрлийн яам Хууль зүйн яам  Хууль зүйн яам Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам  Аймаг, нийслэлийн Засаг дарга, салбар зөвлөлүүд  Аймаг, нийслэлийн Засаг дарга, салбар зөвлөлүүд
Гурав. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд  1. Хар тамхи, мансууруулах бодисын холбоотой гэмт хэргийн тухай нэгдсэн ойлголттой болох, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар төр, захиргаа, хууль хяналтын байгууллагуудын удирдах ажилтны семинар зохион байгуулах	2000-2001 оны I улиралд	Үндэсний зөвлөл, Сангийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Шинжлэх ухааны академи, Орхон, Сэлэнгэ, Дархан-уул, Дорнод, Ховд аймгийн Засаг дарга

Засгийн газрын 2000 оны 34 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

## ХАР ТАМХИ, МАНСУУРАЛТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1	2	3
2.Эмийн тухай хууль, Эрүүгийн хуульд хар тамхи, мансууруулах бодисын холбогдолтой хэргийн тухай тодорхой хэсгүүдэд зохих нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах	2000 оны П улиралд	Үндэсний зөвлөл Хууль зүйн яам Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам
3.Хар тамхи, мансуурлын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаархи иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих	2000 оны Ш улирлаас	Хууль зүйн яам Цагдаагийн ерөнхий газар Мансууруулах бодисоос хамгаалах нийгэмлэг
4.Цагдаагийн байгууллагын төлөөлөгч, байцаагч, шинжээч, гаалийн байцаагч, хяналтын прокурор нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, шатагсан сургалтад хамруулах, гадаад орны туршлага судлуулах	2000 оноос	Хууль зүйн яам Цагдаагийн ерөнхий газар Улсын ерөнхий прокурорын газар Улсын гаалийн ерөнхий газар
5.Хар тамхи, мансууралтай холбоотой гэмт хэргийн тухай ойлголт болон түүнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга тактикийг Цагдаагийн академийн сургалтын программд оруулах	2000 оны П улирлаас	Цагдаагийн ерөнхий газар
6.Хар тамхи, мансууруулах бодисын холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гадаад орны цагдаагийн байгууллагууд, Интерполтой хамтран ажиллах	2000 оноос	Хууль зүйн яам Цагдаагийн ерөнхий газар

Дарга	-Хууль зүйн сайд
Орлогч дарга	-Цагдаагийн ерөнхий газрын дарга
Гишүүд:	-Тэгнуулын ерөнхий газрын дарга; -Хилийн цэргийн удирдах газрын дарга; -Улсын гаалийн ерөнхий газрын дарга; -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга; -Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Салбарын бодлогын зохицуулалтын газрын дарга; -Гэгээрлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Гадаад харилцааны яамны Олон улсын байгууллагын газрын дарга; -Сангийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга; -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга; -Сэтгэцийн эмгэг, наркологийн төвийн захирал; -Радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга; -Нийслэлийн Засаг даргын орлогч; -Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэнгийн захирал; -Эм биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын албаны дарга; -Хүүхдийн төлөө үндэсний төвийн дарга /өөртэй нь тохиролцоноор/; -Монголын Залуучуудын Холбооны ерөнхий нарийн бичгийн дарга /өөртэй нь тохиролцоноор/; -Мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн /өөртэй нь тохиролцоноор/
Нарийн бичгийн дарга	-Эрүүгийн цагдаагийн газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга.



## МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Сайдын зөвлөлийн 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Магистр, доктор /Ph.D/-ын сургалт эрхлэхэд баримтлах үлгэрчилсэн журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан шинжлэх ухаан, боловсролын сайдын 1995 оны 245 тоот тушаалаар баталсан "Монгол Улсын дээд боловсролын зэрэг олгох журам" Гэгээрлийн сайдын 1998 оны 281 тоот тушаалаар баталсан "Магистр, доктор /Ph.D/-ын зэргийн сургалт явуулахад баримтлах

нийтлэг журам"-уудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү үлгэрчилсэн журамд нийцүүлэн магистр, доктор /Ph.D/-ын сургалтын журмыг 2000 оны 1 дүгээр сард багтаан боловсруулан баталж мөрдөхийг магистр, докторын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий их сургууль, коллежийн захирал нарт үүрэг болгосугай.

САЙД

А.БАТТӨР

Гэгээрлийн сайдын 1999 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 286 дугаар тушаалын хавсралт

### МАГИСТР, ДОКТОР /Ph.D/-ЫН СУРГАЛТ ЭРХЛЭХЭД БАРИМТЛАХ ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг зүйл

1. "Дээд боловсролын тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн дээд боловсролын магистр, доктор /Ph.D/ /"доктор /Ph.D/-ийг цаашид доктор гэнэ/-ын зэргийн сургалт зохион байгуулахад энэхүү үлгэрчилсэн журмыг баримтална.

2. Энэхүү үлгэрчилсэн журмын зорилго нь Монгол Улсын магистр, докторын сургалтын агуулга, зохион байгууллатын нэгдмэл байдлыг хангах, уг сургалтын төвшинг олон улсын жишигт нийцүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх, дээд боловсрол олгох үйл

ажиллагааны уян хатан байдлыг хангахад оршино.

3. Магистр, докторын боловсролын агуулга нь шинжлэх ухаан, технологи, нийгэм, хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн хүрээнд өндөр төвшинд ажиллахад шаардагдах мэдлэг, чадвар, судалгаа, туршилтын арга зүйг олгоход чиглэнэ.

4. Их сургууль, коллеж нь энэхүү журамд тогтоосон шаардлагуудаас гадна эрх бүхий байгууллагаас магистр, докторын сургалтын талаар гаргасан бусад нормативуудыг мөн дагаж мөрддөг байна.



5. Байгууллагын хэмжээнд баримтлах сургууль, коллежийн удирдах зөвлөл буюу түүнээс эрх олгосноор эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн батална. Энэхүү журамд суралцагчдын улирлын ачааллын дээд хэмжээ, дүн болон голч дүнд тавих босго шаардлага, өөр байгууллагаас авч болох кредитийн дээд хэмжээ, сурлагаар хасах болон дахин шалгалт өгөх нөхцөл, төгсөгчдийн авсан байх нийт кредит ба дүнгийн босго шаардлага, магистрын болон докторын ажлын сэдэв сонгох, бичих болон хамгаалахад тавих тодорхой шаардлага, сургалтын хэлбэр, сургалтын чиглэлийг өөрчлөх болон сургалтын норматив ба дээд хугацаа, элсэлт, элсэгчдэд тавих шаардлага зэрэг сургалтын явцад үүсдэг харилцааг зохицуулах асуудлыг заавал тусгана.

6. Докторын сургалтыг зөвхөн их сургууль дээр зохион байгуулна.

### **Хоёр. Сургалт эрхлэх зөвшөөрөл**

7. Их сургууль, коллеж нь магистр, докторын сургалтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагаас тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.

8. Магистр, докторын сургалт зохион байгуулах санал гаргаж буй их сургууль, коллеж зохих загварын дагуу гаргасан өргөдөл /Маягт 1/, түүний хавсралт материалуудыг сургалт эхлэхээс 5-аас доошгүй сарын өмнө боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Өргөдөлд хавсаргах дор дурдсан материалыг 2 хувь үйлдэн нэг хувийг өөртөө хадгална.

8.1. Магистр, докторын сургалт нээх тухай эрдмийн зөвлөлөөр сайшаасан албан ёсны санал;

8.2. Сургалт нээх үндэслэл, тооцооны тухай танилцуулга;

8.2.1. Энэхүү танилцуулгад тухайн сургалтыг эрхлэх болсон үндэслэл, нээх гэж буй сургалтад зайлшгүй шаардлагатай бэлтгэлийг хэрхэн хангасан байдал, тухайн төвшний сургалтын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах албан тушаалтан,



нэгжид тавих шаардлага, сургалт эхлүүлэх өдөр, тухайн байгууллагын багш нараас нээх чиглэлээр хийж буй судалгаа, шинжилгээний ажил, түүний үр дүнгийн байдал зэргийг тусгана.

8.3. Сургалт явуулахад шаардлагатай барилга байгууламж, анги танхим, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, ном зохиол, мэргэжлийн сэтгүүлийн хангамжийн баталгаа /чиглэл төвшин бүрээр/;

8.3.1. Дээр дурдсан баталгааны тухай материалд магистрын болон докторын сургалт зохион байгуулахад зориулагдсан анги танхимыг хэрхэн буй болгох /өргөтгөл барих, шинээр барилга худалдаж авах, одоогийн хүчин чадалдаа багтаан өрөө танхимууд гаргах г.м./ тухай нотолгоо, сургалт эхлэхэд бэлэн болгосон байдал зэргийг тусгана. Түүнчлэн зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, ном зохиол, мэргэжлийн сэтгүүлийг хэрхэн бүрдүүлсэн, тэдгээрийн тоо хэмжээ, хангамжийн байдлыг тусгана.

Энд дурдсан зүйлүүдийг бэлэн болгоход шаардагдах нийт зардал, түүний эх үүсвэр, тэдгээрийн баталгааг харуулна.

8.4. Тухайн сургалт эрхлэхтэй холбогдсон санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа;

8.4.1. Уг баталгаанд магистр, докторын сургалт явуулахтай холбогдсон санхүүгийн эх үүсвэр, орлого зарлагын тооцоо, хэдэн магистрант, докторант сургах хүчин чадалтай болохыг тусгаж нотолно.

8.5. Сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийн тодорхойлолт;

8.6. Багшийн хангамж;

8.6.1. Хичээл заах үндсэн ба цагийн багш нарын нэр, боловсролын зэрэг, тэдний заах хичээл, магистрын болон докторын ажил удирдах багш нар, багш нарын биеийн товч байцаалт /Маягт-2/ зэргийг гаргаж ирүүлнэ.

8.7. Магистр, докторын боловсрол олгох

сургалтын журмууд.

9. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

Хавсралт материалууд бүрдэл болоогүй бол ирүүлсэн материалыг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан буцаана.

10. Шаардлагатай гэж үзвэл магистр, докторын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн материалд шинжээчдийн хэсэг томилон дүгнэлт гаргуулна. Уг хэсгийн үйл ажиллагаатай холбогдох зардлыг өргөдөл өгсөн этгээд хариуцна.

11. Магистр, докторын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг сайдын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох албан тушаалтан уг тушаалыг үндэслэн тухайн байгууллагын тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулж бичнэ. Хэрэв тушаалд урьдчилан биелүүлбэл зохих зүйлийн талаар заалт орсон бол түүнийг хангасны дараа тусгай зөвшөөрөл олгоно.

12. Их сургууль, коллеж магистр, докторын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахаас өмнө магистрант, докторант элсүүлэх тухай нийтэд зарлах, сурталчлах, элсүүлэхээр тохиролцох, элсэлт авахыг хориглоно.

## ГУРАВ. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

13. Магистр, докторын сургалтыг албан ёсоор батлагдсан сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу явуулна. Магистрант, докторантын сургалтын төлөвлөгөөг их сургууль, коллежийн захирал буюу түүний эрх олгосон этгээд батална.



14. Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад Гэгээрлийн сайдын 1998 оны 255 тоот тушаалаар баталсан "Сургалтын баримт бичиг боловсруулахад баримтлах журам"-ын 12, 15, 16, 17, 18-дахь заалтуудыг удирдлага болгоно.

15. Өмнөх сургалтын кредит цагийг оролцуулан магистрын сургалт 150 /үүний 30-аас цөөнгүй нь магистрын түвшний сургалтад хамаарах/-иас доошгүй кредит цаг байх бөгөөд магистрын төвшний сургалтын агуулгад шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний арга зүйн чиглэлийн хичээл 6-аас доошгүй, гадаад хэлний хичээл 3-аас доошгүй, мэргэжлийн хичээл 12-оос доошгүй кредит цаг, магистрын ажил 6 кредит цаг байх жишиг барина.

Гадаад хэлний хичээл нь тухайн хэлээр мэргэжлийн ном зохиол чөлөөтэй унших, мэргэжлийн чиглэлээр санал бодлоо солилцох, ажлын хураангуйг гадаад хэлээр туурвих чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.

16. Өмнөх сургалтын кредит цагийг оролцуулан докторын зэргийн сургалтын агуулгын багтаамж 210 /үүний 60-аас цөөнгүй нь докторын түвшний сургалтад хамаарах/-аас доошгүй кредит байх бөгөөд докторын түвшний сургалтын агуулгад эрдэм шинжилгээний ажлын арга зүй, мэргэжлийн философийн чиглэлтэй хичээл 6-аас доошгүй, мэргэжлийн хичээл 27-оос доошгүй кредит цаг, докторын ажил 12 кредит цаг байх жишиг барина.

17. Магистрын сургалт нь судалгаа-шинжилгээний болон мэргэжлийн чиглэлээр ахисан түвшинд мэргэших гэсэн хоёр янзын чиглэлтэй байж болно.

18. Магистрант, докторант нь зохих кредитийг цуглуулсны дараа нэгдсэн шалгалт өгнө. Нэгдсэн шалгалтын үндсэн зорилго нь судалгаа шинжилгээ хийх чадвар хир эзэмшсэн, сургалтын төлөвлөгөө ёсоор судалсан хичээлүүдийг хооронд нь уялдуулан нэгтгэж, өөрийн болгосон байдлыг үнэлж, дүгнэхэд оршино.

19. Магистр /доктор/-ын ажлын онолын төвшин, практикийн ач холбогдол, шийдлийг шүүн хэлэлцэж, зохих боловсролын зэрэг олгох эсэх шийдвэр гаргах үүрэг бүхий магистр /доктор/-ын зэрэг хамгаалуулах комиссыг сургуулийн захирлын тушаалаар суралцагч нэг бүрээр байгуулна. Магистрын зэрэг хамгаалуулах комисс нь тухайн салбараар докторын зэрэг хамгаалсан 9-өөс цөөнгүй хүний бүрэлдэхүүнтэй байх ба нийт бүрэлдэхүүний гуравны нэгээс цөөнгүй нь өөр байгууллагын төлөөлөл байна.

20. Зэрэг хамгаалуулах комисс нь гишүүдийн гуравны хоёроос доошгүй бүрдэлтэйгээр магистр /доктор/-ын ажил хамгаалуулах бөгөөд шийдвэрийг нууц санал хураалтаар, дийлэнх олонхийн саналд тулгуурлан гаргана. Сургалтын хөтөлбөрөө бүрэн биелүүлж, магистр /доктор/-ын ажлаа амжилттай хамгаалсан хүнд тухайн чиглэлээр магистр /доктор/-ын зэрэг олгох шийдвэрийг зэрэг хамгаалуулах комиссын хуралдаанаас гаргана. Үг шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар дээд боловсролын магистр, докторын зэрэг хүртээж, диплом олгоно.

Магистр /доктор/-ын зэрэг хамгаалуулах шалгалтыг нээлттэй явуулна. Хамгаалах шалгалт болон комиссын хурлын тэмдэглэлийг хадгална.

21. Магистр, докторын ажлыг монгол хэлээр, харин хураангуйг гадаадын аль нэг түгээмэл хэлээр бичнэ. Докторын ажил ба түүний хураангуйн нэг хувийг Улсын нийтийн номын сан, Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн сан болон тухайн сургалтын байгууллагын номын санд албан ёсоор өгнө. Магистрын ажлын нэг хувийг тухайн сургалтын байгууллагын номын санд албан ёсоор өгнө.

22. Сургалтын төлөвлөгөө ёсоор үзэх хичээлүүдийг оруулан тооцсон магистрантын голч дүн нь 3.0-оос доошгүй, докторантын голч дүн нь 3.25-аас доошгүй байна. Тухайн байгууллага голч дүнгийн босгыг энд дурьдсанаас дээгүүр тогтоож болно.

23. Магистрын зэргийн түвшинд суралцагчид С-ээс доошгүй, докторын зэргийн түвшинд суралцагчид В-ээс доошгүй үнэлгээтэй байвал зохино. Түүнчлэн тодорхой хичээлүүдэд дээр дурдсанаас дээш үнэлгээтэй сурах шаардлага тавьж болно. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдэд "Тооцов", "Үл тооцов" үнэлгээг хэрэглэхгүй.

## ДӨРӨВ. БАГШ НАР

24. Магистрын зэрэг олгох сургалтад хичээл заадаг багш нар нь магистраас доошгүй зэрэгтэй, харин докторын зэрэг олгох сургалтад мэргэжлийн хичээл заадаг багш нар нь бүгд тухайн хичээлийн чиглэлээр докторын зэрэгтэй байвал зохино.

25. Багш нар өөрийн мэргэшил буюу судалгаа шинжилгээнийхээ чиглэлийн дагуу хичээл заадаг байна.

26. Багш нар нэг бүр судалгаа шинжилгээний ажил эрхэлж, мэргэжлээрээ өсөхийн төлөө байнга чармайлт гаргадаг байна.

27. Магистрын, докторын төвшний сургалтад хичээл заадаг багш нарт тухайн хичээлийн онцлог, хөдөлмөр зарцуулалтад нийцсэн цалин хөлс өгдөг, сургалтын цагийн ноогдлын хөнгөлөлт үзүүлдэг байна.

28. Магистрын удирдагчаар доктороос доошгүй зэрэгтэй, 5-аас цөөнгүй жил дээд боловсролын сургуульд багшилсан буюу эрдэм шинжилгээний ажил хийж тодорхой бүтээл гаргасан, докторантын эрдэм шинжилгээний удирдагчаар шинжлэх ухааны докторын буюу доктор зэрэгтэй, дадлага, туршлага бүхий багш, эрдэмтдийг ажиллуулна. Гадны байгууллагаас удирдагч томилох бол тухайн чиглэлээр магистрын болон докторантын удирдагчаар ажиллуулах үндсэн багш, гадны байгууллагын хүмүүсийн тооны харьцаа 1:1-ээс хэтрэхгүй байвал

зохино.

29. Магистрын ажлын удирдагч нь сүүлийн 3 жилд 3-аас цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлсэн, докторын ажлын удирдагч нь энэ шаардлагаас гадна сүүлийн 3 жилд нэгээс цөөнгүй ганц сэдэвт эрдэм шинжилгээний бүтээл бичиж хэвлүүлсэн байвал зохино.

30. Магистр, докторын ажлын удирдагч нь суралцагчийн судалгааны ажлын төлөвлөгөөг боловсруулах, судалгааны ажил хийх, магистрын болон докторын ажил бичих явцад хяналт тавьж, тогтмол зөвлөгөө өгөх үүрэгтэй.

31. Нэг удирдагчийн удирдах магистрантын тоо тухайн хичээлийн жилд 5-аас ихгүй байвал зохино. Харин докторантын тоо 3-аас ихгүй байвал зохино.

32. Дээд боловсролын байгууллага нь санхүүгийн тусламж болон бусад хөнгөлөлт үзүүлэх, ажлын байрыг нь баталгаажуулах зэргээр багш нарынхаа судалгаа шинжилгээний ажил эрхлэх идэвхи, санаачлагыг дэмждэг байх ёстой.

## ТАВ. НОМЫН САН, МЭДЭЭЛЛИЙН ХАНГАМЖ

33. Номын сан нь магистр, докторын төвшний сургалтын чиглэл бүрд шаардагдах хэмжээний ном зохиолтой байхаас гадна мэргэжлийн сэтгүүл, ном зүйн лавлагаа, ганц сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний цуврал зэргийг бүрдүүлж, байнга сэлбэн баяжуулах замаар тухайн сургалтыг дэмжих таатай нөхцлийг буй болгох ёстой.

24. Номын сангийн чанарыг ном зохиолын хамрах цар хүрээ, төвшин, шинжлэх ухааны янз бүрийн салбарыг төлөөлж чадахуйц эх сурвалж болж буй байдал, ном хэвлэлийн шинэлэг байдал, үйлчилгээний төвшин гэх



ээрэг хүчин зүйлээр тодорхойлно. Номын сангийн нөөцийг тухайн төвшний сургалт, судалгааны ажилд гарч буй хэрэгцээ, шаардлага, төрийн ба тухайн боловсролын байгууллагын стратегийн зорилго, бодлогод гарч буй өөрчлөлтөд нийцүүлэн тухай бүр шинэчлэж байвал зохино.

35. Номын сан нь магистрын болон докторын сургалтад суралцагчдын тоог харгалзсан, тэдэнд зориулсан суудал бүхий нээлттэй уншлагын танхим ажиллуулах чиглэл баримтална.

36. Магистрант, докторант номын санд интернет ашиглах боломжийг хангана.

## **ЗУРГАА. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ**

37. Магстр, докторын төвшний сургалт эрхэлдэг байгууллагууд судалгаа шинжилгээний ажил хариуцсан удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байна.

38. Магистр, докторын сургалт эрхлэх тухайн чиглэлээр 3-аас доошгүй жил суурь болон хавсарга судалгаа шинжилгээний ажлыг өөрийн мэргэшсэн, туршлагатай багш нарын хүчээр тасралтгүй явуулж, энэхүү судалгааны ажилд зохих хөрөнгө төсөвтөө тусган зарцуулж ирсэн байх шаардлагатай.

39. Сургуулиуд өөрийн багш нарын судалгаа шинжилгээний ажлын дүн, шинжлэх ухааны салбар бүрт хийсэн шилдэг төсөл буюу эрдэм шинжилгээний өгүүлэл болон доктор, магистрын сайшаагдсан ажлын талаарх дүгнэлт, хураангуй зэргээс сонгон авч оруулсан эрдэм шинжилгээний цуврал /сэтгүүл/-ыг жил тутам нийтэлдэг байна.

## **ДОЛОО. ЭЛСЭЛТИЙН ШААРДЛАГА**

40. Элсэлтийн бодлого, элсэгчдэд тавих

шаардлага нь бакалаврын дараачийн зэргийн сургалтад амжилттай суралцаж чадах хүмүүсийг сонгон шалгаруулж, элсүүлэхэд чиглэсэн байна.

Докторантаар элсэх хүмүүс нь магистрын зэрэгтэй, магистраар элсэх хүмүүс нь бакалаврын зэрэгтэй буюу түүнтэй дүйцүүлэх боловсролтой, түүнчлэн тухайн боловсролын байгууллагаас тавьсан шаардлагуудыг хангасан байвал зохино.

Магистрын сургалтад элсэх хүний бакалаврын сургалтын голч дүн нь 2.75-аас, докторын сургалтад элсэх хүний магистрын сургалтын голч дүн нь 3.25-аас тус тус доошгүй байхаар элсэлтийн босго голч дүнг боловсролын байгууллага бүр тогтооно.

41. Өөр чиглэлээр дараагийн зэргийн сургалтад хамрагдах бол өмнөх зэргийн нь сургалтын агуулгыг эзэмших сургалтад хамрагдан зохих хэмжээний кредит бүхий хичээл үзсэн байхыг шаардана.

42. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу суралцах хүсэлтээ албан ёсоор тавьсан гадаадын иргэдийг эрх бүхий сургууль элсэлтийн шалгалт авч суралцуулах асуудлыг шийдвэрлэнэ. Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу суралцуулах хүмүүсийн асуудлыг хэлэлцээрт заасан нөхцөлөөр шийдвэрлэнэ.

43. Элсэлтийн шалгалтад тэнцсэн хүнийг суралцуулах тухай захирлын тушаал гарснаар элссэнд тооцно. Тушаалд сургалтын чиглэл, мэргэшил, эрдэм шинжилгээний ажлын удирдагчийг тодорхой заасан байна.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай гэж үзвэл элсэлтийн талаар нийтлэг зохицуулалт хийх эрхтэй.

Маягт 1

/Тусгай зөвшөөрөл олгох байгууллагын нэр/

## ӨРГӨДӨЛ

Огноо:

- д

/Боловсролын байгууллагын нэр/

 дор дурдсан чиглэлээр магистрын, докторын сургалт  
 эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно уу.

Сургалтын чиглэл индекс	Санал болгож буй нөхцлүүд							
	Эзэмшүүлэх Боловсролын зэрэг	Сургалтын хэлбэр	Суралцагчдын тоо /-ээс ихгүй/			Элсэгчдийн Боловсролын төвшин	Сургалтын хугацаа	Сургалтын дараа Олгох боловсролын зэрэг
			1 дахь жил	2 дахь жил	3 дахь жил			

ГАРЫН ҮСЭГ

Маягт 2

## МАГИСТР, ДОКТОРЫН ЗЭРГИЙН СУРГАЛТАД ХИЧЭЭЛ ЗААХ БАГШИЙН БИЕИЙН БАЙЦААЛТ

1. \_\_\_\_\_

/Багшийн овог, нэр/

2. Төрсөн он . . . . .

3. Хүйс . . . . .

4. Одоо ямар байгууллагад ямар албан тушаал дээр ажилладаг

5. Боловсролын болон эрдмийн зэрэг:

### А. Магистрын зэрэг

	Төгссөн сургууль	Төгссөн он	Сургалтын чиглэл
1.			
2.			
3.			

### Б. Доктор /Ph.D/-ын зэрэг

	Төгссөн сургууль	Төгссөн он	Сургалтын чиглэл
1.			
2.			

### В. Шинжлэх ухааны докторын зэрэг

	Төгссөн сургууль	Төгссөн он	Сургалтын чиглэл
1.			

6. Сургалтад оролцох чиглэлээр ажилласан /дээд сургуульд хичээл заасан, эрдэм шинжилгээний байгууллагад ажилласан хугацаа:

7. Сургалтад оролцох чиглэлээр гаргасан судалгаа, сургалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээл /монограф, сурах бичиг, гарын авлага, илтгэл, өгүүлэл/-ийн тоо



7.1. Сүүлийн 5 жилд бичиж хэвлүүлсэн бүтээлүүдийн нэрс, хаана хэвлэгдсэн:

8. Удирдаж хамгаалуулсан:

а/ магистрантын тоо /хичээлийн жилээр/

б/ докторантын тоо /хичээлийн жилээр/

9. Одоо аль түвшинд ямар хичээл заах /нэрийг тодорхой бичих/

а/ Магистрантурт:

б/ Докторантурт:

10. Одоо ямар төвшинд, ямар чиглэлээр магистрант, докторант удирдах:

Биеийн товч байцаалт бичсэн: \_\_\_\_\_

*/Гарын үсэг/*

Хянасан: \_\_\_\_\_

*/Тэнхмийн эрхлэгчийн нэр, Гарын үсэг/*

Танилцсан: \_\_\_\_\_

*/Магистр, докторын сургалт хариуцсан албан тушаалтны нэр, гарын үсэг/*

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг  
эрхлэх газрын харьяа  
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☎ 327806  
320407